



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/309

Булган сум

**Боксын өсвөрийн шигшээ багийн тамирчдын
хэрэглэл, материалын зардалд
дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн боксын өсвөрийн шигшээ багийн тамирчдын хэрэглэл, материалын зардалд 2,750,000 (хоёр сая долоон зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн “Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ